

## МОНГОЛЧУУДЫН УРАГ ХУРИМЫН ЁСТОЙ ХОЛБООТОЙ ХЭДЭН НЭРИЙН ТУХАЙ

МУБИС-ийн багш  
Д.Соронзон /магистр/

Монгол хэлэнд ургийн нэр үүсэх үндсэн нөхцөл нь хүний төгөлдөржсөн нийгмийн үндсэн нэгж болох өрх гэрийн гишүүдээс шууд хамааралтай юм. Энэ талаар судлаач Вэн Еин үзэхдээ: “Төрөл садны дуудлага нэрийдэл нь тухайн үндэстний түүх, соёл, зан заншил, шашин суртахуун зэргийг тусгадаг. Гэхдээ үндэстнүүдийн төрөл садны дуудлага нь нийгмийн хөгжил ба ураг хуримын дүрмийн хөгжлийг дагалдан төгөлдөрждөг” (1:31) хэмээн бичжээ.

Ураг холбож, эхнэр нөхөр болох тухай ойлголт нь хүний нийгэм, сэтгэхүйн хөгжлийн харьцангуй хожуу үед үүссэн тул хэлэнд тэмдэглэсэн цаг хугацаа нь ч мэдээж хожуу үед хамаарна. Нийгэм, өрх гэрийн зохион байгуулалт, угсаатны ёс заншилтай холбоотойгоор монгол хэлний үгийн санд нөхөр, эхнэрийг нэрлэсэн өдий төдий олон үг үүсэж, утга бүтцийн үлэмж хувьсалд оржээ.

Эрт цагт аль нэг овгийн залуус эрчүүд харь овгоос эмс охидыг булаан авчирч гэрлэдэг ёс байсан бөгөөд түүнийгээ “эм авах” хэмээн нэрлэдэг байв. Иймээс ч “Монголын нууц товчоо”-нд “Добу мэргэний авсан ёсон тийм” (17:24) гэх мэтээр гардаг билээ. Судлаачид үүнийг мөн “булаамал ураг” гэж нэрлэх нь бий. Эдүгээ монголын зарим нутгийн хуримын ёсонд эхнэрийг нууцаар мордуулан оддог нь дээрх ёсны ул мөр юм. Одоо бас ярианы хэлэнд “эхнэр авах” гэж ярьдаг. Ташрамд, мөн ярианд хааяа “нөхөр авах” хэмээн хэлэлцэх болсон нь үнэхээр эрт цагт ихэс ноёдын охид нөхөр авдаг ёс монголчуудын дунд байсантай холбоотой бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдох энэ мэт жишээ, хэллэг орчин цагийн нийгэмд давтагдаж буй нь сонирхолтой юм. “Монголын нууц товчоо”-ны 156-р зүйлд: “ ... Tatar-un Yeke Ćeren-ü Yisüi neretei ökin ökdeksen güregen gü'ün büle'ei bi” (17:112) гэж гардаг нь дээрхийн жишээ мөн болно.

Тухайн цаг үеийн язгууртан нар хоёр ба түүнээс олон хатантай байсан зэрэг нь олон эхнэртэй байж болох ёс оршсоор байсныг харуулж байна. Ийнхүү гэрлэсэн эмэгтэйчүүдийг авааль эм, житүгээр эм, багахан эм (11:1199) мэтээр нэрлэдэг байсан бол буриадын зарим аялгуунд мөн утгатай ехэлэй (2:218), багалай (2:76) гэсэн үгс ч үлдсэн байна. Харин үр хүүхэд нь тэднийг “эх нэр”, “ээж нэр” (11:1191) мэтээр нэрлэдэг байсан ба өөр хоорондоо биесээ ажин, авьсан гэж дууддаг байв.

Эдүгээ Ордос нутгийн аялгуунд “авьсан” гэдэг үг нь “Нэг эрийн хэдэн эхнэрийн харилцан дуудах нэрийдэл” (9:6) гэж байгаагаас үзвэл, ажин, авьсан мэтийн эдгээр үг нь эрт цагт нэг эрийн хэдэн эхнэр өөр хоорондоо биесээ насаар ялган нэрийддэг үг байсны баримт юм. Харин орчин цагийн халх аялгуунд “Ахын эхнэр, дүүгийн эхнэрийн авьсан” (15:18) болсны учир нь нийгэмд оршихоо байсан үзэгдэл, ойлголтыг нэрлэсэн үгсийн утга шилжсэнээр тайлбарлагдана.

Монгол хэлний ургийн нэрийн бүрэлдэхүүн цаашид баяжин хөгжсөн байдлыг тухайн цаг үеийн монгол хэлтний нийгэм, аж амьдралын зохион байгуулалттай холбон үзэх нь илүү оновчтой юм.

Дундад үеийн монгол хэлний дурсгалд “хадам” гэх үг дангаараа эмийн эцгийг заасан утгатай тэмдэглэгдсэн нь (*Үүнтэй адил тохиолдол түрэг, манж-түнгүс хэлэнд бас бий.*) тохиолдлын хэрэг биш төдийгүй, уг нэрийн үүссэн нөхцөл шалтгааныг тодруулахад чухал баримт болдог.

Хойшид “хадам” хэмээх үг “эх” гэдэг үгтэй холбогдсон ч мөн л эмийн эхэд хамаарах нэр болж байсан нь энэ үеийн бичгийн дурсгалуудад элбэг тохиолддог. Улмаар энэ үг эхнэрийн ах, эгч, дүү нарт хамаатай тодотголын үүрэгтэй болсон (8:85) бол эдүгээ бүр нөхөр ба эхнэрийн төрөл садны ямар ч хүнийг дуудаж болох ерөнхий чанартай нэр болсон байна.

Энэ байдал түрэг, манж-түнгүс хэлнүүдийн хувьд мөн адил юм. Иймд эхнэр хүн “хадам” гэдэг үгийг хэрэглэх болсон явдал нь тун хожуу үед хамаарах ба аналогитой холбон үзүүштэй. Өөрөөр хэлбэл, эр нөхөр нь өөрийн эцэг, эхийг эцэг /аав/, эх /ээж/ гэх буюу эхнэр нь мөн ялгалгүй эцэг, эх хэмээн дуудна. Харин эр нь өөр овогт байгаа эхнэрийн эцгийг төрөл ёсны эцэг хэмээн ухаарна. Ингэж ойлговол, энэхүү хадам хэмээх үг бол өөр овгоос эмс охидыг булаан олзолж ирдэг үеийн хэлний баримт биш, харин ч худ ураг болж, найр тавин авчирдаг ёсны үлдэгдэл ажээ.

Монгол хэлний зарим дурсгалд “худ овог” хэмээх нэгэн үг тохиолддог нь (11:1228) монголчуудын дунд овгийн систем хүчтэй байх цагт хоёр овог харилцан эмс охид солилцвол худ овог болдог байсан үеийн хэлний баримт бөгөөд тэр нь сүүлдээ хоёр өрх гэрийн хоорондох ураг төрлийн харилцааны шинжтэй болсон байна. Ингэж худ ураг бололцохыг эрт цагт “худлах-” гэдэг байсныг “Монголын нууц товчоо”-ны 185-р зүйл дэх “...*ökin kö'ün töre'esü ečige eke anu ö'erün dura'ar bü qudalatuqai*” (17:143) гэсэн өгүүлбэрээс мэдэж болно. Ийнхүү ураг садан бололцохыг зарим нутагт эдүгээ бас “урагцаах-” хэмээн нэрлэдэг нь (10:26) “ураг болцгоох” гэдгээс үүссэн бололтой.

Харилцан бэр авсан худыг “андлай худ” хэмээн нэрийдэх бөгөөд бас худ болсон хүмүүс хоорондоо бие биеэ “худ анд” гэж дууддаг байжээ. “Халимаг - Орос толь” (1977)-ийн 607-р талд “хойр күүкэн өгч, хөөт үзгт нутгт бүүрлүлэд **худ-анд** болж” гэсэн жишээ байдаг бөгөөд “бүүрлүүлх” гэдэг нь “суулгах” гэсэн утгатай.

Хойшид олонх монгол хэл, аялгуунд утга нь нэгэнт хэвшээд байсан “худ” хэмээх үгэнд хүндэтгэсэн утгатай “агай” гэдэг үгийг холбож, худ агай → худгай → худгуй зэрэг хэлбэрийг үүсгэсэн байна. Гэвч эдгээр хэлбэр зарим аялгуунд охины талыг нийтэд нь нэрлэсэн утгатай үлдсэн бол нөгөө тохиолдолд хоёр талын эмэгтэй хүмүүст хамаарах ерөнхий нэр болж тогтжээ.

“Монголын нууц товчоо”-нд дээр дурдсан “худлах-” гэдэг үгээс гадна мөн ойролцоо утгатай “арилжих-” гэсэн үг нэг удаа тохиолддог. 165-р зүйлд: “Тiний хойно, амраг дээр давхар амраг больё гэж Чингис хаан сэтгэж, Зiчид Сэнгiмийн дiй Чаур бэхийг гуйж, бас Сэнгiмийн хевiйн Тусахад eepийн Хожин бэхийг **арилжин** eгье гэж гуйвал...” (5) гэсэн өгүүлбэрийн “арилжих-” гэдэг үгэнд “худлах-” гэдгийг бодвол хоёр овог харилцаа тогтоох, түүнийгээ бэхжүүлэх гэсэн санаа илүү давамгайлж байна. Өөрөөр хэлбэл, үүнийг харь овгоос эмс охидыг булааж ирэх, найр тавьж худ ураг болох хоёр ёсны завсрын шинжтэй үзэгдэл хэмээн ойлгож болмоор ажээ.


Дээр өгүүлсэнчлэн тухайн үеийн монголчуудын дунд өөр овгоос эхнэрийг булаан авч ирэх, эсвэл тухайн овогтой найрамдалт харилцаа тогтоож эмс охид солилцох, цаашлаад худ овог бололцохоос өмнөх шатад буюу барагцаалбал, эхийн эрхт ёсны сүүлч үед эр нь эмийн талд очиж амьдардаг ёс байсныг судлаачид нэг биш удаа тэмдэглэжээ. (3, 12) Ийм жишээг Барга ястанд уламжлагдсан байсан “Хүргэн хөвгүүн эхийн урагт өнө амьдарч эхнэртэйгээ ханицан анхны хүүхэд төрсний дараа гэргий хүүхдийн хамт өөрийн төрсөн гэр уугуул овогтоо буцаж ирдэг заншил байжээ” (3:123) гэсэн жишээнээс харж болох юм. Мөн ийм ёсны үлдэгдэл нь хуримын инж өгөх боломжгүй ядуу айлын хүү хадмын гэрт очиж амьдрах, эсвэл хүн бүл муутай айлд хүргэн болж орох зэрэг хэлбэрээр уламжлагдсан байна. Ийм хүргэнийг “хүчин хүргэн”, “хүчний хүргэн”<sup>1</sup> хэмээн нэрлэдэг төдийгүй хадам эцэг, эхийг нас эцэслэсний хойно өв хөрөнгийг нь залгамжлан үлддэг онцлогтой бөгөөд Ордост харин “үрэ хүргэн” гэж дуудна. Түүнийг “өв идэж, өр төлөх хүргэн” хэмээн тайлбарлажээ. (9:98) Мөн Ордос аялгуунд байгаа “хүргэн өгөх-”, “хүргэн авах-”, “хүргэнчлэх-” /гэртээ суулгах/, “хүргэн суух-” (9:231-232) мэтийн үгс нь ураг хуримын дээрх ёсны онцлогийг хадгалсан үгс юм. Одоо бас бидний дунд “айлд хүргэн орох-” гэж ярьдаг нь ч үүнтэй холбоотой. Үүнтэй тун ойролцоо өөр нэг үзэгдлийг агуулсан “тэжээвэр бэр” гэсэн үг бичгийн дурсгалд тохиолддог (11:1205) бөгөөд үүнийг

<sup>1</sup> Хүчний хүргэн - Барилга үгүйгээр охин өөрийн гэрт холбож аж төрөх нөхрийг. (16:443)

судлаач Намсрай: “Ураглах насанд хүрээгүй өнчин охин буюу хүүхдээ тэжээхэд хүчирдэж байгаа айлын бяцхан охиныг гэртээ авчирч гар зуур зарж, ажил амьдралын ёс сургаж байгаад хуримлах насанд хүрвэл хүүтэйгээ ураглуулсан бэрийг тэжээвэр бэр гэнэ” (7:45) хэмээн тайлбарласан байна.

Хэдий дээрх мэт ёс байсан ч монгол хэлний “хүргэн” гэдэг үг эхийн эрхт нийгэмд үүссэн гэж үзэх нь эргэлзээтэй байна. Түүнчлэн олон судлаач энэ үгийн гадаад бүтцийн тохиолдлын шинжид дулдуйдаж гаргасан санаагаа улам лавшруулж, элдэв янзын үг хэл, бэлэг сэлт хүргэх ёстой хутган, улмаар “хүрч ирсэн хүн” гэсэн агуулгатайгаар үүссэн гэж дүгнэжээ. Харин судлаач Түмэнжаргал “Монгол хэлний “хүргэн” гэдэг үгийн тухай” (1998) гэсэн өгүүлэлдээ “хүргэн” гэх үгийг “хүү” гэсэн үгтэй нэг язгууртай байсан тухай санал гаргасныг бусдаасаа өвөрмөц бөгөөд бодитой байдлаар тайлбарласан хэрэг гэж бид үзэж байна. Үнэхээр “хүргэн” гэсэн утгатай үг үүсээгүй байх цагт түүнийг “хүү” гэсэн үгээр төлөөлүүлэн хэлж байсан байж болохыг үгүйсгэх аргагүй. Хэрэв ингэж бодвол, хүргэн хүү гэсэн санаа нь түрүүлэн үүсээд хожим хүргэн дүү, хүргэн ах гэсэн үгс бий болсон байж таарна. Энэ учраас уул үгийг С.Шагжийн тольд “Охинд холбосон нөхрийг” (16:457), “Хорин наймт тайлбар толь”-д “Охины эрийг хүргэн хэмээмүй” (14:1068) гэж тайлбарласан ба “Монгол хэлний товч тайлбар толь” (1966)-д “Охины ханилсан нөхөр” гээд хойно нь хүргэн хүү, хүргэн ах, хүргэн дүү гэсэн үгсийг жагсаан бичсэн (15:747) нь угтаа уул үгэнд “охины нөхөр” гэсэн санаа нь хадгалагдан яваагийн илрэл билээ.

Монгол төрөл хэл, аялгуунуудын “хүргэн” гэсэн үгтэй холбоотой өвөрмөц сонин зүй тогтолт үгсийн баримтыг жагсаавал: “хүргэн хүү”-г *ür xürgen* (Ord.), “хүргэн дүү”-г *kure dü: ~ quda* (SY.), *deu xurgun* (Dag.), *dü: kürgen* (Alsha.), *dü: xürx* (Barga.), “хүргэн ахыг” *xür ax ~ xüreg ax* (Tsakh.) гэх мэтээр хэлдэг байна. (18:401-402) Эдгээр үгсийн хоршсон байдал нь тодорхой зүй тогтолгүй мэт харагдавч угтаа хэлний үгийн хувьслыг тун нарийн хадгалсан эмх журам бүхий тогтолцоо болно. Түүнийг дараах байдлаар загварчлан тайлбарлая.



Эрт цагт “хүргэн” гэдэг ойлголт тогтворжоогүй байхдаа утга нь зарим үед нөхөр, худ гэсэн үгстэй ч тохирдог байжээ. Үүний учир нь хүргэн хүү бол хадам буюу эхнэрийн төрхмийн төрөл саданд нэг талдаа хүргэн хүү боловч нөгөө талдаа охины нөхөр болох тул түүнд “нөхөр” гэсэн утга тогтсон бололтой. “Дүү” гэсэн үг өмнөө орсон тохиолдолд уул үг “нөхөр” гэсэн утгатай болж байгаа бөгөөд монгол хэлэнд “дүү хүр” гэдэг холбоо үг үүсээгүйн

шалтгаан нь “хүр” гэдэг үгэнд ерөөс “нөхөр” гэсэн утга үүсээгүйд оршино. Үүнийг тухайн хэлбэрийн утга ямар байснаас хамаараад тодотгол үг нь өмнөө орж явдаг байжээ хэмээн ойлгож болох юм. Түүнчлэн хүргэн дүү, дүү хүргэн гэсэн хоёр үг яагаад нэг ойголтыг зааж буйн учир гэвэл нэг нь “хүргэн дүү” гэдэг талаас нь нэрлэсэн, нөгөө нь “дүүгийн нөхөр” гэдэг талаас нь ялгасан хэрэг болно. Цаашлаад хүргэн хүү бол эхнэрийн төрөл саданд худ овгийн хүн болох тул мөн “худ” гэсэн утгатай болсон байна. Иймээс хүр дүү, хүр охин дүү гэх зэрэг үг үүссэн байх. Энэ талаар профессор Хасуми Харуо: “Хүр гэдэг нь эр эм бололцсон хоёр талын бие биеийн харилцааг заасан утгатай үг байсан гэж үзэж болох юм” (13:218) гэсэн билээ.

Дээр өгүүлснийг товчлон хэлбэл, өнөөгийн монгол хэлний “хүр” хэмээх үг нь “хүү үр → нөхөр → охины нөхөр” гэсэн ерөнхий утгатай байжээ. Түүнчлэн “бэр” хэмээх нэр ч “охин үр → /эхнэр/ хүүгийн эхнэр → дүүгийн эхнэр” гэсэн утгатайгаар хувьссан байна. Дундад үеийн монгол хэлний “бэр” гэдэг үгэнд өөрийн эхнэрийг заасан утга байсан бөгөөд эдүгээ Өвөрмонголын зарим аялгуунд мөн ийм үзэгдэл буйн дээр “хүргэн” гэх нь “нөхөр” гэсэн утгатай байдаг талаар судлаач Жараннэг дурджээ. (4:85-86)

“Монголын нууц товчоо”-ны 65-р зүйлд Дэй Сэцэн: “Нуган хийхэд нутгаа эзэмшинэ. Охин хийхэд енгэ шилэгдэнэ” (5) гэж хэлдэг нь эцгийн эрхт ёсны үеийн харь овгоос эхнэр авч гэрлэдэг ёсыг тусгасан үг болно. Ингэж ирсэн эмэгтэйг цөм “бэр хүн” хэмээн дуудах бөгөөд хожим зөвхөн ахын гэргийг нэрлэсэн “бэргэн” гэсэн үг олон монгол хэл, аялгуунд нийтлэг хэлбэр, утгатайгаар дэлгэрсэн боловч өнөөгийн Дархад аялгуунд буй “бэргэ” гэх үг нь хүү ба дүүгийн эхнэр, эсвэл ахын эхнэрийг ялгалгүй нэгэн адил “бэр” гэсэн утга агуулгаар хэрэглэгддэг ажээ. (6:116) Ташрамд монгол хэлэнд бэр, бэргэнийг заасан хорь шахам нэр бий.

Монголчуудын дунд хүргэн ах ба бэргэн нь өөрөөс дүү байсан ч ах, эгчээр үзэх буюу хүргэн дүү ба бэр нь биеэс ах, эгч байсан ч дүүчлэн үздэг ёс уламжлагдан үлдсэн нь ах, дүүг хэрхэн ялган үзэх монголчуудын зан заншлын өвөрмөц онцлог болох бөгөөд энэ нь төрөл садны нэрийн бүрэлдэхүүнд насаар ялгасан бусад олон үг үүсэх нөхцөл болжээ.

### Дүгнэлт

Монгол хэлний үгийн сан нь түүхийн урт удаан хугацаанд хүний нийгэм, сэтгэхүйд шинээр гарч ирж буй үзэгдэл, ойлголтыг дагалдан утга агуулга, бүрэлдэхүүний талаас ямагт хувьсан өөрчлөгдсөөр иржээ.

Монгол туургатны ураг хуримын ёсны дүрэм, өрх гэрийн зохион байгуулалтын онцлогийг хадгалсан дээрх хэдэн үгсийн анхдагч утга нь бидэнд ихэнхдээ мэдэгдэхээ больсон байх тул тэдгээр нэрийн үүсэж бүтсэн утгын онцлог, зүй тогтлыг амьд хэл, аялгууны болоод бичгийн дурсгалаас нягтлан тодруулж гаргах нь чухал ач холбогдолтой зүйл болно.

### Summary

The terms depending on the tribe and relative custom of the Mongolian roof was remained a lots in the mongolian language vocabulary. These have been specific characteristic and changed its contents and constitution for long time of the history. However, during studying the noun vocabularies and significs in the contemporary Mongolian language, accent and script memorials, it is very significant for the language, culture and ethnic.

### Номзүй

1. *Вэн Еин., Төрөл садны нэрийдлээс ураг хуримын дүрэм ёсны ул мөрийг ажиглах нь, - МХБ. 4(2000), 31-36*
2. *Гантогтох, Г., Буриад аялгууны толь, Уб., 2010 (2011), 720 х.*
3. *Гонгор, Д., Халх товчоон. 2, Халх монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал (11-17-р зуун), Уб., 1978, 366 х.*

4. *Жараннэг, Монгол хэлний төрөл садны харьцааны нэрийн тухай, - МХБ. 3(1981), 79-87*
5. *Монголын нууц товчоо, Уб., 1992,*
6. *Мөөмөө, С., Мөнх-Амгалан, Ю., Орчин үеийн монгол хэл, аялгуу, Уб., 1984, 314 х.*
7. *Намсрай, Монгол хэлний төрөл садны дуудлагуудын учир утга, - МХБ. 7(1991), 40-49*
8. *Рыкин, П. О., Семантический анализ терминов родства и свойства в среднемонгольском языке, - ВФ. Серия "Урало-алтайские исследования". 1(2009), 80-91*
9. *Соном., Ордос аман аялгууны үгсийн хураангуй, ӨМҮХХ, 1999, 472 х.*
10. *Сэржгочоо, Д., Монголчуудын ураг хуримын ёсон дахь садан төрлийн нэрийдлэгийн сүвэгчлэл, - МХБ. 1(1996), 26-28*
11. *Таван зүйлийн үсгээр хавсарсан Манж үгний толь бичиг, ӨМҮХХ, 1957, 1667 х.*
12. *Түмэнжаргал, Монгол хэлний "хүргэн" гэдэг үгийн тухай, - ӨМИС. 2(1998), 75-82*
13. *Хасуми Харуо., Монгол хэлний хүний эшийн холбогдолтой зарим үгсийн тухай, - ОУМЭИХ III, 2, 1977, 216-219*
14. *Хорин наймт тайлбар толь, ӨМАХХ, 1994, 2012 х.*
15. *Цэвэл, Я., Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1966, 911 х.*
16. *Шагж, С., Монгол үгний тайлбар толь, ДУҮХХ, 1994, 933 х.*
17. *Ligeti, L., Histoire secrete des Mongols, Budapest, 1971, 265 pp.*
18. *Sun Zhu., Menggu yuzu yan cidian, Qinghai, 1990, 844 p.*